

Экспортод гаргаж буй ашигт малтмалын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлан



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЭКСПОРТОД ГАРГАХ ТӨРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ АЛДАГДЖЭЭ

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар

Захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

Г.Цэдэнбалжир

Шинжээч

Т.Батзориг

Ж.Ганчимэг

С.Пүрэвсүрэн

С.Одонцэцэг

2012 оны 12 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Вэб
сайтаас үзнэ үү.

www.mnao.mn

Аудитын тайлан дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 262451,
261885 дугаарын утас,
факсаар харилцана уу.

Хаяг

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг, Бага
тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт

Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан
хүрээ, арга зүй 3

Аудитад ашигласан хууль тогтоомж,
шалгуур үзүүлэлт 3

Нэгдүгээр бүлэг

**Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг
зохицуулсан бодлого оновчтой бус, хэрэгжилт
хангалтгүй байна** 4

Ерөнхий зүйл 4

1.1 Эрдэс баялгийн салбарт уул уурхайн
бүтээгдэхүүний экспортыг зохицуулсан
бодлого, чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй
байна 4

1.2 Уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан
борлуулах, экспортлох үйл ажиллагааг
нэгтгэн зохицуулах бирж үгүйлэгдэж байна 10

1.3 Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох
үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин
боловсронгүй бус байна 10

1.4 Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний
тонн тутамд ногдох үр өгөөж бага байна 11

Хоёр дугаар бүлэг

**Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үйл
ажиллагаа үр дүн муутай хэрэгжиж áàéíà** 14

2.1 Уул уурхайн бүтээгдэхүүний баримтлах
жишиг үнийг зах зээлийн эх сурвалжид
тулгуурлан гаргаж олон нийтэд мэдээлэх
ажлын хэсгийн үйл ажиллагаа хангалтгүй
байна 14

2.2 Газрын тосны бүтээгдэхүүн хуваах
гэрээг боловсронгуй болгох шаардлагатай
байна 17

2.3 Лабораторийн шинжилгээгээр ашигт
малтмалын дагалдах элементүүдийг бүрэн
тодорхойлохгүй байна 25

Дүгнэлт 27

Зөвлөмж 28

Холбогдох байгууллагын санал 31

**Монгол Улсын Ерөнхий аудиторын
тушаал** 34

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам (хуучнаар)
ЭБЭХС	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд (хуучнаар)
УУЯ	Уул уурхайн яам
УУС	Уул уурхайн сайд
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар (хуучнаар)
АМГ	Ашигт малтмалын газар
ГТГ	Газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам (хуучнаар)
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
СЯ	Сангийн яам
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ҮХШХ	Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГаТЛ	Гаалийн төв лаборатори
ГеТЛ	Геологийн төв лаборатори
ТЗУГ	Төмөр замын удирдах газар
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ХАМО	Хувиараа ашигт малтмал олборлогч
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ӨННААТ	Өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ЗЦГ	Замын цагдаагийн газар

Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2012 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Экспортод гаргаж буй ашигт малтмалын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн, төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал, үйл ажиллагааг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийв.

- Экспортод гаргаж буй ашигт малтмалын талаар хэрэгжүүлж буй бодлого, оновчтой, үр дүнтэй эсэх,
- Ашигт малтмалыг экспортлох үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад ЭБЭХЯ (хуучнаар) УУЯ, АМГ, ГТГ, ГЕГ, ТЕГ, МХЕГ, ГеТЛ, СХЗГ болон холбогдох газар хэлтэс, Дархан, Эрдэнэт, Дорнод, Дорноговь аймгийн Гаалийн салбар хороод болон бусад байгууллагууд хамрагдсан болно.

Тус аудитад холбогдох байгууллагуудын 2008-2012 оны үйл ажиллагааны тайлан, бодлогын баримт бичиг, судалгаа, мэдээлэл, эрх зүйн баримт бичгүүд болон бусад баримт материалуудыг хянан шалгаж, нэгтгэн дүгнэсэн бөгөөд 2012 оны 8 дугаар сарын 15-аас 2012 оны 11 дүгээр сарын 16-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав.Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох ажилтнуудтай ярилцлага хийх, тайлбар тодруулга авах, судалгаа гаргуулах,
- Уул уурхайн болон газрын тосны экспорттой холбогдуулан ажиглалт хийх, зураг авч баталгаажуулах,
- АМГ, ГТГ, ГЕГ, ТЕГ, МХЕГ- аас уул уурхайн экспортын бүтээгдэхүүнтэй холбогдсон тоон мэдээллүүдийг гаргуулах, түүнд дүн шинжилгээ хийх,

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгаа, тайлан, тайлбарыг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад Үндэсний хөгжлийн цогц бодлого, Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Газрын хэвлийн тухай хууль, бусад хамааралтай материалуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Бүлэг 1. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг зохицуулсан бодлого оновчтой бус, хэрэгжилт хангалтгүй байна

Ерөнхий зүйл

1.1. ҮСХ-ноос гаргасан судалгаагаар 2011 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 21.7 хувь, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 60.7 хувийг уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн эзэлж байна.

1.2. Монгол Улсын экспортын бүтцийг барааны бүлгээр авч үзвэл, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ 2008-2011 онд 60.3-89.2 хувиар өссөн байна. Нэгдсэн төсвийн орлогод 2011 онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 251.746.8 сая төгрөг төвлөрчээ.

1.3. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын 2011 оны байдлаар авч үзвэл, нүүрс 21296.0 мянган тонн, зэсийн баяжмал 575.9 мянган тонн, жонш 407.1 мянган тонн, цайрын баяжмал 121.2 мянган тонн, боловсруулаагүй газрын тос 2553.7 мянган баррелийг тус тус экспортолжээ¹.

1.1 Эрдэс баялгийн салбарт уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг зохицуулсан бодлого, чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна

1.4. Эрдэс баялаг, эрчим хүчний яам (хуучин нэрээр) уул уурхайн бүтээгдэхүүнийг олборлох, баяжуулах, боловсруулах хүнд үйлдвэрийн цогцолборыг байгуулах замаар нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, экспортын бодлого боловсруулах чиг үүрэгтэй байв.

1.5. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд² *“Экспортын чиглэлтэй үйлдвэрлэл үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд татварын болон урамшууллын бодлогоор дэмжлэг үзүүлнэ”* хэмээн тусгажээ.

1.6. Тус хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тухайлбал,

- Ашигт малтмалын тухай хуулийн төсөл боловсруулж, холбогдох дүрэм, журам боловсруулан батлах;
- Бүрэн боловсруулалт хийх технологи бүхий газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах;
- Стратегийн ач холбогдол бүхий ордын авто зам, төмөр зам барих техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж хөрөнгө оруулагчдад санал болгох, хөрөнгө оруулалтын гэрээнд тусган хэрэгжүүлэх.

1.7. УИХ-ын 2011 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичигт “Монгол Улсын үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий газрын тосны салбарт хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлэх, газрын тосны нөөцийг өсгөх, олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах, газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, үндэсний аж үйлдвэрийн суурийг бий болгох” гэж заажээ.

¹ Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. 2011. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. Улаанбаатар

² Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар. 2012. “Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2012 оны эхний хагас жилийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан”

1.8. ЭБЭХЯ-наас ажлын хэсэг томилон “Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого”, “Нүүрсний салбарыг хөгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого”, “Эрдэс баялгийн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” зэрэг үндсэн баримт бичгүүдийг боловсруулсан боловч албан ёсоор батлагдаагүй байна.

Түүнчлэн дээрх чиг үүрэгт дурдагдсан уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

1.9. **Ашигт малтмалын газар** уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн байдалд судалгаа хийх, уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, ашигт малтмал ашигласны төлбөр, татварын орлогын статистикийн мэдээлэл боловсруулах, нүүрсний үнийн зах зээлийн судалгаа тооцоо хийх, зах зээлийн шинэ орчинг бүрдүүлэхэд ЭБЭХЯ-ыг мэдээллээр хангах чиг үүргийг гүйцэтгэж байгаа боловч нүүрсний экспортод хяналт тавих бодлогыг хэрэгжүүлээгүй байна.

1.10. Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам” батлагджээ. Ашигт малтмалын газрын 2010 оны судалгаагаар, нийт 16 аймаг, Улаанбаатар хотын 1 дүүрэгт 61000 гаруй хувиараа ашигт малтмал олборлогчид ажиллаж, үүнээс 98.42 хувь нь алтны үндсэн ба шороон ордод олборлолт явуулж байжээ³.

1.11. Орон нутгийн төсвийн төлөвлөлтөд орлогыг нь тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварыг суулгаснаас хувиараа ашигт малтмал олборлогчдын талаарх статистик мэдээг аймаг, сумд 2011 оноос АМГ-т ирүүлэхээ больжээ. Бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алт Монголбанкнд тушаагддаг болон бусад ашигт малтмалыг хэрхэн худалдан борлуулдаг эсэх нь тодорхойгүй байна.

1.12. **Газрын тосны газар** бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны экспортын орлогын Монгол Улсын Засгийн газарт ноогдох тосны тооцоог хийх, тосны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах, газрын тос олборлох, цуглуулах, цэвэршүүлэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааны явцад хяналт тавих, олборлолт, борлуулалтын тайлан мэдээг хүлээн авч, хянаж баталгаажуулах чиг үүрэгтэй байна.

1.13. Газрын тосны итгэмжлэгдсэн лаборатори байгуулах, 2.0 сая тонн түүхий тос боловсруулах хүчин чадал бүхий газрын тос боловсруулах үйлдвэрийг Дархан-Уул аймагт барих арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.14. **Гаалийн ерөнхий газар** Монгол Улсын гаалийн хяналтын бодлого тодорхойлох, олон улсын гэрээ конвенци, Дэлхийн гаалийн байгууллагын стандарт зөвлөмж, гадаад худалдааг хөнгөвчлөх, худалдааны аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, гаалийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.15. Харин гаалийн тарифийн зохицуулалтын арга хэмжээний талаар санал боловсруулах чиг үүргийн хүрээнд “Зарим бараанд экспортын гаалийн ялгавартай тариф тогтоох тухай” хуулийн төслийг боловсруулсан боловч батлагдаагүй байна.

³ Ашигт малтмалын газрын Уул уурхай, судалгааны хэлтэс статистик мэдээлэл судалгааны хэлтэс. 2012. Уул уурхайн салбарын 2011 оны үйл ажиллагааны тухай. Улаанбаатар

1.16. Гаалийн харилцаанд оролцогчдын экспорт, импортын үйл ажиллагааг гаалийн зорилгоор нягтлан шалгах, үнэлэлт дүгнэлт өгөх чиг үүргийн хүрээнд БНХАУ, ОХУ-ын гаалийн байгууллагуудын хоорондох статистик мэдээллийн зөрүүг таамаглал төдий дэвшүүлдэг бөгөөд судалгааны үр дүнг хяналтын стратеги, эрсдэлийн тооцоонд ашиглах ажлыг хэрэгжүүлээгүй байна. Дархан-Уул аймгийн гаалийн салбар хороо 2009 оноос эхлэн ГЕГ-ын Эрсдэлийн удирдлага, үнэлгээ бүрдүүлэлтийн шалгалтын хэлтсийн даргын албан бичгийн дагуу ГатЛ-ийн дүгнэлтийг үндэслэн төмрийн хүдрийн баяжмалаас чийгийн хэмжээг хасаж цэвэр жингээр бодож хураамжийг тооцож байгаа боловч аж ахуйн нэгж, байгууллагууд нэхэмжлэлээ бохир жингээр тооцон төлбөрийг авч байна.

1.17. “Биржийн нэр зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоол, “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2010 оны 39 дүгээр тогтоолууд нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуультай зөрчилдөж байна. Ингэснээр үнэлгээний анхдагч суурь үнийн 1 дүгээр арга буюу хэлцлийн үнийн арга болон бусад үнэлгээний аргуудыг дэс дараалан хэрэглэдэг гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй үнэлгээний хяналтын зарчмууд алдагдахад хүргэж шууд 4 дүгээр арга болох зах зээл, мэдээлэл, судалгааны аргыг хэрэглэж байна.

1.18. Түүнчлэн “Гааль-бизнесийн түншлэл” буюу гаалийн байгууллагаас үйлчлүүлэгчдэд, хууль ёсны гадаад худалдаа эрхлэгчдийг дэмжин ажиллах, олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөгдөж буй зорилго, зорилтоо биелүүлэхэд энэхүү үнэлгээ нь сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

1.19. Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элсэн орсон бөгөөд гаалийн тарифыг нь “0” байлгахар тохиролцсон бараанаас бусад экспортын бүх бараандаа “0” хувийн экспортын гаалийн татвартай байдлаар гадаад худалдааг зохицуулан ажиллаж байна.

1.20. Уул уурхайн бүтээгдэхүүнийг гаалийн татвартай болгох боломжийг ДХБ- тай тохиролцох эсхүл аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг нэмэгдүүлэх замаар эрдэс баялгийн салбараас Улсын төсөвт орох үр өгөөжийг дээшлүүлэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

1.21. Мөн мөрдөгдөж байгаа эрх зүйн орчны дагуу ашигт малтмал экспортлоход ямар нэгэн татваргүй байгаа бөгөөд Гаалийн тухай хуулийн 26.2 дахь хэсэг, Сангийн сайдаас өгөгдсөн чиглэл, ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2010 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ГЕГ-ын даргын 2010 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 402 тоот тушаалаар экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамжийг 1000 кг тутамд 1000 төгрөг, нүүрсний 1000 кг тутамд 1500 төгрөг тооцон авч гаалийн бүрдүүлэлтийг хийж байна.


1.22. **Татварын ерөнхий газар** уул уурхайн экспортын бүтээгдэхүүнээс улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байгаа бөгөөд уул уурхайн салбарт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар болон бусад татвар, төлбөр, хураамжуудыг ногдуулан ажиллаж байна.

1.23. Газрын тосны салбарын хувьд Монгол Улсын Засгийн газар газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтыг аж ахуйн нэгж байгууллагуудтай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах зарчмаар зохицуулж буй онцлогтой байна.

1.24. Тамсаг-ХХИ, БХГ-97 гэрээт талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (роялти)-ийг 7.5 хувь байхаар тус тус тусгасан байна. Харин Тосон-Уул XIX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (роялти)-ийг тус Бүтээгдэхүүн хуваах гэрээний 8.1 дэх Төлбөр (роялти) хэсэгт “Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг МГТ компани Монголын Засгийн газарт төлнө” хэмээн тусгаснаар тус талбайгаас роялти төлөгдөөгүй байна.


1.25. ТЕГ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тооцож авахын тулд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 39 дүгээр тогтоолыг үндэслэн Татварын ерөнхий газрын даргын 2010 оны 322 дугаар тушаалаар “Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тооцох аргачлал”-ыг баталж, Татварын ерөнхий газар, Улсын төсвийн орлого, хяналтын газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтсүүдэд мөрдүүлсэн байна.

1.26. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний харьцангуй их хувийг нүүрсний экспорт, төмрийн хүдэр, цайрын хүдэр, баяжмал тус тус эзэлж байна. 1 тонноос дээш хэмжээтэй экспортолсон нүүрсний 59, төмрийн хүдэр, баяжмалын 44, жоншны 80,



цайрын хүдэр, баяжмалын 3, газрын тосны 2 аж ахуй нэгж байгууллагуудын 2010-2012 оны 9 дүгээр сарын байдлаар нийт төлсөн татварын хэмжээг графикаар харуулав.


1.27. Нүүрс экспортолж буй аж ахуйн нэгж байгууллагуудын татвар төлөлтийн байдлыг графикаас харахад, 2011 онд нүүрсний салбарын экспортын хэмжээ 21.4 сая тонн болж улсын төсөвт төвлөрүүлсэн татвар төлөлтийн хэмжээ 424.5 тэрбум төгрөг буюу хамгийн оргил үедээ хүрчээ. Тухайлбал, “Монголын Алт” ХХК 128.2 тэрбум төгрөг, “Энержи ресурс” ХХК 65.2 тэрбум төгрөг, “Саусгоби сэндс” ХХК 42.9 тэрбум төгрөгийг тус тус



улсын төсөвт оруулсан байна.

1.28. Нийт төлсөн татварын хэмжээг төрлүүдээр нь авч үзвэл, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) илүү өндөр хувьтай байгаа бөгөөд түүний дараа аж ахуй нэгжээр орлогын албан татвар (ААНОАТ) орж байна.


1.29. Төмрийн хүдэр, баяжмал олборлон борлуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын татвар төлөлтийн байдлыг графикаас харахад, 2011 онд төмрийн



хүдрийн экспортын хэмжээ 5.8 сая тонн болж, улсын төсөвт төвлөрсөн татвар төлөлтийн хэмжээ 45.5 тэрбум төгрөг буюу оргил үедээ хүрсэн байна. Нийт төлсөн татварыг төрлөөр нь ялган авч үзвэл, 2011 онд 24.5 тэрбум төгрөгийг AMHAT-т төлснөөс “Болдтөмөр Ерөө гол” ХХК 50 орчим хувь буюу 14 тэрбум төгрөг, “Алтайн хүдэр” ХХК 7.4 тэрбум төгрөгийн AMHAT-ээг тус тус улсын төсөвт төвлөрүүлжээ.

төлөлтийн байдлыг графикаас харахад, 2010 онд жоншны экспортын хэмжээ 405.5 мянган тонн болж, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар төлөлтийн хэмжээ 4.4 тэрбум төгрөгт хүрч байжээ. Үүнийг татварын төрлүүдээр нь авч үзвэл, 2010 онд 3.8 тэрбум төгрөгийг AMHAT-т төлснөөс “Монголросцветмет” ХХК 90 гаруй хувийг дангаараа буюу 3.3 тэрбум төгрөгийн AMHAT-ийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

1.30. Жонш экспортолж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын татвар



1.31. Ашигт малтмалын төрөл тус бүрээр авч үзэхэд, цөөн хэдэн аж ахуйн нэгж байгууллагууд татварын дийлэнх хувийг бүрдүүлдэг байна.

1.32. Манай улсын төсвийн орлого бүрдүүлэлт уул уурхайн экспортын орлогоос шууд хамааралтай байна. 2012 оны 9 дүгээр сарын байдлаар нүүрсний экспортын хэмжээ харьцангуй буурсан нь БНХАУ-д нүүрс, төмрийн хүдэр, баяжмалын

хэрэглээ ихээхэн буурч, тус улсын эдийн засаг удааширч, нөгөөтэйгүүр Европын орнууд, АНУ-ын эдийн засаг хямралтай байгаагаас урд хөршийн экспортын бэлэн бүтээгдэхүүний худалдан авалт буурсантай шууд холбоотой гэж шинжээчид үзэж байгаа юм.

1.33. Иймээс, нүүрс болон ашигт малтмал экспортолсон аж ахуйн нэгж байгууллагын татвар болон төлбөрийн орлого харилцан адилгүй байгаад шинжилгээ хийж, улсын төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах нь зүйтэй байна.

1.34. ТЕГ-т жишиг үнийн ажлын хэсгээс мэдээлж буй төмрийн хүдэр, баяжмалын агууламж тодорхой бус, жишиг үнийн сарыг давхцуулан тавих, тайлбарыг ойлгомжгүй бичих, уул уурхайн экспортын бүтээгдэхүүнд олгож буй Гаалийн лабораторийн дүгнэлт зэргээс шалтгаалан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг ногдуулахад хүндрэл учирч татварын алба аж ахуйн нэгжүүдийн хооронд маргаан үүсэж байна.

1.35. **Мэргэжлийн хяналтын ерөнхий газар** ашигт малтмал, газрын тосны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, улсын болон орон нутгийн төсөвт оруулах төлбөр, хураамжийн төлөлтийн байдалд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

1.36. Харин Хилийн мэргэжлийн хяналтын алба экспортолж буй ашигт малтмалд нийтлэг шаардлага тавьдаг, уул уурхайн мэргэжлийн боловсон хүчин цөөн, итгэмжлэгдсэн лабораторигүй, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний талаар чиг үүрэг тодорхойгүй, ажиллах нөхцөл, эрх зүйн орчин хангалтгүйгээс ашигт малтмалыг экспортлох үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.

1.37. Нүүрс экспортлох тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас хөрсний эвдрэл бий болж, тоосжилт үүсгэн говийн экосистемийг алдагдуулж, цөлжилтийг нэмэгдүүлэн тухайн орчинд амьдарч байгаа иргэд, малчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл, мал амьтны бэлчээр нутгийг доройтуулж байгааг тогтоосон боловч хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээг орхигдуулсан байна.

1.38. Замын цагдаагийн газраас гаргасан мэдээгээр, зөвхөн Өмнөговь аймгийн Цогт Цэций, Ханбогд, Гурван тэс, Баян-Овоо сумдад ашигт малтмал олборлолт, нүүрс тээвэрлэлтийн автомашинтай холбогдсон зам тээврийн осол сүүлийн 3 жилд 259 бүртгэгджээ. Уг ослын улмаас 20 хүн нас барж, 11 хүн гэмтсэн байна. Гарсан ослын хэлбэрээс үзвэл, хоорондоо мөргөлдсөн 190 буюу 73.4 хувь, онхолдсон 69 буюу 26.6 хувь бөгөөд 517,4 сая төгрөгийн хохирол учирсан байна.

1.39. Ашигт малтмалын тухай хуулийн 10.1.7-д Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, хяналтын ажлыг үр дүнтэй болгох зорилгоор “Ашигт малтмал эрэх хайх, ашиглахтай холбоотой бусад үйл ажиллагааны журам батлах” гэж заажээ.

1.40. Үүний дагуу холбогдох байгууллагуудаас “Ашигт малтмал хил нэвтрүүлэх экспортлоход дагаж мөрдөх журам”-ын төслийг боловсруулан Хууль зүйн яаманд санал авахаар хүргүүлсэн боловч ЭБЭХС-ад ашигт малтмалыг хил нэвтрүүлэх, экспортлох асуудлаар журам батлах эрх хуулиар олгогдоогүй гэсэн үндэслэлээр буцаажээ.

1.41. АМГТХЭГ, ГЕГ ажлын уялдаа холбоогоо сайжруулах, гаалийн хяналтыг хөнгөн шуурхай болгох зорилгоор 2007 онд 471/815 дугаартай хамтарсан тушаал баталжээ.

1.42. Гэвч АМГТХЭГ-ын тодорхойлолт өгч байгаа байдалд ашигт малтмал экспортлогч аж ахуйн нэгжүүд гомдол гаргасан, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл учруулсан гэсэн үндэслэлээр Гаалийн ерөнхий газрын дарга 2008 оны 358 дугаар тушаалаараа дээрх хамтарсан тушаалыг дангаараа хүчингүй болгосон байна.

1.43. Дээрх байгууллагуудын уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагаа, түүнд тавих хяналт уялдаа холбоогүй байгаагаас гадна, ашигт малтмалын худалдаа, борлуулалтыг зохицуулах, хянах, нэгтгэн зангидах байгууллага алга байна.

1.2 Уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, экспортлох үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах бирж үгүйлэгдэж байна

1.44. Дэлхийн олон орны туршлагаас харахад “уул уурхайн бүтээгдэхүүний бирж” байгуулах замаар төр, бизнесийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, ашигт малтмалын худалдаа, экспортод тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэж байна. Хөгжиж байгаа орнуудын хувьд бирж нь аливаа нэгэн тооцоолоогүй болон хүсээгүй үнийн хэлбэлзэл, эрсдэлээс хамгаалахад ихээхэн үр дүнтэй байдаг ажээ.

1.45. Мөн макро эдийн засгийн түвшинд санхүүгийн секторт ахиц гарч, хөрөнгө оруулагчид уул уурхайд хөрөнгө оруулах боломж бүрдэх, татварын хяналт сайжирч, улсын төсвийн орлого нэмэгдэх, дотоодын үйлдвэрлэл өсч, ажлын байр шинээр бий болох, тээвэр зууч, агуулахын аж ахуй, даатгалын зах зээл хөгжих, бүтээгдэхүүний чанар стандартын түвшин өсч, үйлдвэрүүдийн уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинд ахиц гарах, тэдгээр бүтээгдэхүүний арилжаанд оролцох гадаадын худалдан авагчдын тоо нэмэгдэж, экспортын үнэ өсөх зэрэг ач холбогдолтой гэж үздэг байна.

1.46. Манай оронд уул уурхайн бирж байгуулагдсанаар ашигт малтмалын гадаад, дотоод худалдаа түүгээр дамжин хийгдэж, ямар аж ахуйн нэгж аль ордоос ямар төрлийн ашигт малтмалыг хэр хэмжээтэй олборлож хэнд ямар үнээр худалдан борлуулсан нь дуудлага худалдаанд оролцож буй бүх субъектэд ил тод байх нөхцөл бүрдэж, шударга, үр дүнтэй худалдаа хөгжих боломж байна.

1.47. Биржийн худалдааны мэдээллийг татвар, гааль, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагууд татан авснаар мэдээллийн нэгдсэн систем бүрдэж, төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирч, өнөөдрийн хүндрэл бэрхшээлийг шийдэх боломжтой болно.

1.3 Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн орчин боловсронгуй бус байна

1.48. Монгол Улсад уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг Ашигт малтмалын тухай хуулийн 27, 47 дугаар зүйл, Засгийн газрын 2007 оны 88, 2011 оны 193 дугаар тогтоолуудаар зохицуулж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 27.1.3-т “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхайн эдэлбэрээс олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах”, мөн хуулийн 66.1.1-т “Тусгай зөвшөөрөлгүй этгээд ашигт малтмалын хайгуул хийсэн, ашигт малтмал олборлосон, борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол хууль бусаар олсон орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж, уг этгээдийг 500000-1000000 хүртэл төгрөгөөр торгох” тухай заасан байна.

1.49. Гэвч нүүрсний экспортыг авч үзэхэд, “Эрдэнэт цэций хайрхан” ХХК, “Говь Алмаз” ХХК, “Говь фрийдом” ХХК, “Их говийн андууд” ХХК, “ЭС ДЭ” ХХК, “Нутгийн гоёо” ХХК, “Мил порт” ХХК, “Номгон тулга” ХХК, “Дээдийн говь” ХХК, “Тавантолгой транс” ХХК, “Хүрээ дэл” ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд тусгай зөвшөөрөлгүйгээр худалдан авах гэрээг үндэслэн экспортолж байна.

1.50. Ашигт малтмалын тухай хуулийн 48.6.3-т “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн уулын ажлын тайлан, маркшейдерийн хэмжилтээр

тогтоогдож батлагдсан уулын ажлын үндсэн үзүүлэлтийг болон график зургийг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор батлагдсан маягтын дагуу хүргүүлэх”-ээр заажээ.

1.51. Гэтэл АМГ-ын Уул уурхай, судалгааны хэлтэст 2011 оны байдлаар ⁴, төлөвлөгөө батлуулсан 274 аж ахуй нэгжүүдийн 162 нь буюу дөнгөж 60 орчим хувь нь үйл ажиллагаа явуулсан тухай уулын ажлын тайланг ирүүлсэн байна. Ялангуяа алт, жонш, тоосго, элс хайрганы ордуудад тайлангийн ирц хамгийн бага байна (Алт-50 хувь, тоосго-44 хувь, жонш-60 хувь, элс хайрга-52.2 хувь).

1.52. Батлагдсан уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг авч үзвэл, түүний гүйцэтгэлийн хэмжээ нийт ордуудад 52 хувьтай байна.


1.53. Газрын тосны салбарт Газрын тосны тухай хууль (1991), Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль (2005), Засгийн газрын 1991 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Газрын тосны хуулийг хэрэгжүүлэх журам”, Засгийн газрын 2002 оны “Газрын тосны салбарт авах арга хэмжээний тухай” 267 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжуудыг баримтлан ажиллаж байна.

1.54. ЭБЭХС-ын тушаалаар Газрын тосны тухай хуулийг шинэчлэн найруулж, боловсруулах ажлын хэсгийг байгуулан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

1.4 Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тонн тутамд ногдох үр өгөөж бага байна

1.55. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд Уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээг 2011 оны байдлаар авч үзвэл, Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний цэвэр өсөлт 17.3 хувьд тооцогдож байгаа ба үүнд уул уурхайн салбарын цэвэр өсөлт 8.7 хувьтай байна.

1.56. Экспортын бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувийг 2008-2011 оны



байдлаар харуулсан графикаас үзэхэд, улсын хэмжээгээр экспортод гаргаж буй бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 2011 онд өмнөх оны үзүүлэлтээс 1.4 пунктээр нэмэгдэн нийт экспортын 89.2 хувийг бүрдүүлсэн байна.

1.57. Уул уурхайн экспортын зарим бүтээгдэхүүний үр өгөөжийг Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газрын мэдээллийг үндэслэн тооцож үзэхэд дараах байдалтай байна.

⁴Ашигт малтмалын газрын Уул уурхай, судалгааны хэлтэс статистик мэдээлэл судалгааны хэлтэс. 2012. Уул уурхайн салбарын 2011 оны үйл ажиллагааны тухай. Улаанбаатар

(2010, 2011, 2012 оны 9 дүгээр сарын мэдээгээр)

Ашигт малтмалын төрөл	Он,сар	ГЕГ-ын экспортын мэдээ		Татварын ерөнхий газрын мэдээ	
		Тоо хэмжээ /тн/	Дэлхийн зах зээлийн жишиг үнийн дүн /\$/	Нийт төлсөн татварын хэмжээ /₮/	1 тн тутамд ногдох өгөөж /₮/
Нүүрс (кокс, давирхай, чулуун нүүрс, хүрэн нүүрс)	2010	17 058 175.66	1 120 214 703 946.40	175 264 505 100.00	10 274.50
	2011	21 418 428.80	3 145 417 189 359.50	424 526 174 900.00	19 820.60
	2012.09	14 301 122.61	1 911 422 942 300.00	221 160 832 600.00	15 464.60
Төмрийн хүдэр, баяжмал	2010	3 563 657.52	317 373 764 827.60	23 152 057 800.00	6 496.70
	2011	5 800 022.42	605 504 434 590.00	45 546 517 340.00	7 852.80
	2012.09	4 626 481.00	498 857 335 200.00	36 031 140 400.00	7 788.00
Жонш	2010	405 567.61	86 093 027 015.40	4 439 952 800.00	10 947.50
	2011	407 085.78	130 922 862 190.10	5 625 606 030.00	13 819.20
	2012.09	311 462.12	93 775 465 483.00	4 695 961 400.00	15 077.10
Цайрын хүдэр, баяжмал	2010	119 788.66	167 717 467 285.90	34 311 479 100.00	286 433.40
	2011	121 219.33	179 035 983 655.10	31 847 119 290.00	262 723.10
	2012.09	92 817.31	116 682 722 430.00	16 091 322 300.00	173 365.50

Тайлбар: 1 тонноос дээш хэмжээтэй экспортолсон аж ахуйн нэгжүүдийн мэдээг түүвэрлэн авав. Мөн "Шанлун", "Шинь Шинь" ХХК-уудын татвар төлөлтийн хэмжээ нь цайрын хүдэр баяжмалыг хар тугалганы хүдэр, баяжмалтай нэгтгэсэн байдлаар байгаа болно. ГЕГ-ын үнийн дүн дэх долларын хэмжээг Монгол банкны тухайн жилийн 12-р сарын 31-ний өдрийн албан ханшаар тооцон төгрөгт шилжүүлсэн болно.

1.58. Дээрх хүснэгтэд нүүрс экспортолж буй 59, төмрийн хүдэр, баяжмалын 44, жоншны 80, цайрын хүдэр, баяжмалын 3 аж ахуйн нэгж, байгууллагыг тус тус хамруулсан болно.

1.59. Дээрх тооцооллоос үзэхэд, уул уурхайн зарим бүтээгдэхүүний үр өгөөж дараах байдалтай байна. Үүнд:


- **Төмрийн хүдэр, баяжмал** 2011 онд нийт 5.8 сая тонн, 605.5 тэрбум төгрөгийн төмрийн хүдэр, баяжмал экспортолсноос улсын төсөвт нийт 45.5 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Үүнээс 1 тонн тутамд ногдож буй татварын дүнг тооцон үзвэл, 7852.80 төгрөг буюу маш бага хэмжээний үр өгөөж гарч байна.
- **Нүүрс** 2011 онд 21.4 сая тонн буюу 3 их наяд 71 тэрбум 360 сая төгрөгийн нүүрс экспортолж, улсын төсөвт 424.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулснаас 1 тонн тутамд ногдож буй үр өгөөж 19820.60 төгрөг байна.
- **Жонш** 2011 онд 407.0 мянган тонн буюу 130.9 тэрбум төгрөгийн жонш экспортолж, улсын төсөвт 5.6 тэрбум төгрөг оруулснаас 1 тонн тутамд ногдож буй үр өгөөж 13819.20 төгрөг болж байна.

1.60. Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1-т "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байна", Ашигт малтмалын тухай хуулийн 5.1-д "Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн" гэж тус тус заажээ.

1.61. Гэтэл бид газрын хэвлийд буй байгалийн үнэт баялгаа бага үнээр экспортолж байгаа нь улс орон, ард түмэнд үр өгөөж муутай байна.

1.62. Иймд, Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын талаар төрөөс баримталж буй бодлогыг шинэчлэх шаардлагатай байна.

1.63. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын дийлэнх хэсгийг БНХАУ-тай хийж байгаа бөгөөд үүнээс төмрийн хүдэр, зэс, цайр, цагаан тугалганы баяжмал болон чулуун нүүрсний бүх экспортыг тус улстай хийж байна.



1.64. Экспортод гаргаж буй уул уурхайн бүтээгдэхүүний төрөл тус бүрийн эзлэх хувийг 2011 оны байдлаар харуулсан графикаас үзэхэд, 46.5 хувийг чулуун нүүрс, 20.0 хувийг зэсийн баяжмал, 9.1 хувийг төмрийн хүдэр эзэлж байгаа нь нийт экспортын бүтээгдэхүүний 75.6 хувь болж байна.

1.65. Өөрөөр хэлбэл, экспортод гаргаж буй чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн бүтээгдэхүүнтэй

холбоотой асуудал манай улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой болж байна.

Бүлэг 2. Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагаа үр дүн муутай хэрэгжиж байна

2.1 Уул уурхайн бүтээгдэхүүний баримтлах жишиг үнийг зах зээлийн эх сурвалжид тулгуурлан гаргаж олон нийтэд мэдээлэх ажлын хэсгийн үйл ажиллагаа хангалтгүй байна

2.1. Ашигт малтмалын тухай хуулийн 47.7 дахь “Экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох олон улсын жишиг үнэ тогтоодог биржийн нэрийг тухайн бүтээгдэхүүний нэр төрлийг харгалзан Засгийн газар нийтэд зарлана” гэсэн заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар дараах тогтоолуудыг баталжээ. Үүнд:

3. “Биржийн нэр зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолд “Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээг тогтоохдоо зэс, цайр, цагаан тугалга, хар тугалгыг Лондонгийн металлын биржийн үнээр”, “зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжид алт, мөнгийг Монгол банкны ханшаар”, “төмрийг Австралийн төмрийн үйлдвэрлэгч, Японы ган үйлдвэрлэгчийн хоорондын худалдааны гэрээнд заасан үнэ, жоншийг гол экспортлогч Хятад, гол импортлогч АНУ-ын худалдааны гэрээнд заагдсан үнэ, нүүрсийг Хятадын нүүрсний үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл сэтгүүл (China Coal weekly www.coalword.net) –ийн үнээр үндэслэл болгох”;
- “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 39 дугаар тогтоолд зарим экспортын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний үндэслэл болгох Монгол банкны болон зах зээлийн үнийн эх сурвалжийн нэр”-ийн жагсаалтад перренат аммони (ренийн давс)-ийг ховор металлын зах зээлийн үнийн мэдээлэл гаргадаг www.metal-pages.com, гянтболдыг ХБНГУ-ын Ашигт малтмал, гео-судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргадаг www.bgr.bund.de зэрэг цахим хуудсанд байршуулсан үнийг үндэслэл болгон гэжээ.

3.1. Дээрх тогтоолуудыг үндэслэн дараах тушаалууд гарсан байна. Үүнд:

- “Ажлын хэсэг томилох тухай” Үйлдвэр худалдааны сайдын 2007 оны 135 дугаар тушаалд зах зээлийн үнийн эх сурвалжийн талаарх мэдээллийг гаргаж олон нийтэд мэдээлэх ажлын хэсгийг ҮХЯ, СЯ, АМГТХЭГ, ҮТЕГ, ГЕГ-аас төлөөлөл оролцуулж, нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй;
- “Ажлын хэсэг байгуулах тухай” ЭБЭХС-ын 2010 оны 99 дүгээр тушаалаар Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний баримтлах жишиг үнийг зах зээлийн эх сурвалжид тулгуурлан гаргаж олон нийтэд мэдээлэх ажлын хэсгийг ЭБЭХЯ, СЯ, АМГ, ГЕГ, ҮТЕГ-ын төлөөллийг оролцуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй;
- “Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай” ЭБЭХС-ын 2012 оны 85 дугаар тушаалд дээр дурдсан байгууллагуудын төлөөллийг оролцуулан 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулжээ.

3.2. Гэвч тус ажлын хэсэгт жишиг үнэ тогтоохдоо мөрдөж ажиллах журам байхгүй, хурлын протокол үйлдээгүй, гишүүдэд тухайн сарын уул уурхайн экспортын бүтээгдэхүүний баримтлах жишиг үнэ, түүний зах зээлийн эх сурвалжийн талаар танилцуулга (илтгэл) өгөөгүй, мэдээллээр хангаж ажиллаагүй байна.

3.3. Ажлын хэсгээс 2012 оны 2 дугаар сард гаргасан төмрийн хүдэр, баяжмалын жишиг үнийг тогтоохдоо 66.5 хувийн агуулгатай төмрийн хүдэр, баяжмал 118 ам.доллар, 58.0 хувийнх нь 84.0 ам.доллар гэж үнэлжээ.

3.4. Гэтэл агуулга нь 58.0-66.5 хувийн хоорондох төмрийн хүдэр, баяжмалын хувьд баримтлах жишиг үнэ тодорхой бус байдлаас болж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг зөв тооцож чадахгүйд хүргэж, улмаар татварын алба аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд нөөц ашигласны төлбөрийн маргааныг бий болгох, улсын төсөвт орох орлогод нөлөөлөхөд хүргэсэн байна.

3.5. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний жишиг үнийн мэдээлэлд түүхий нүүрсний жишиг үнээс БНХАУ-ын дотоодод борлуулж байгаа нүүрсний НӨАТ-ын 17 хувийг хасаж тооцсон байна.

3.6. “Биржийн нэр зарлах тухай” Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолд БНХАУ-ын нүүрсний үйлдвэрлэлийн талаарх мэдээлэл сэтгүүл (Chine Coal weekly www.coalword.net) –ийг нүүрсний зах зээлийн үнийн эх сурвалжаар заасан байна. Гэтэл тус сайтад Шангси, Анхун, Шандун, Хэнан мужууд, Өвөр Монголын импортын үнэ тавигдаж байгаа нь олон улсын биржийн үнэ гэж үзэхэд эргэлзээтэй байна.

3.7. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний баримтлах жишиг үнийг олон нийтэд мэдээлэх ажлын хэсэг Өвөр Монголын хойд мужийн нүүрсний импортын үнийг Монгол Улсын нүүрсний экспортын жишиг үнэ болгон тавьж байгаа нь дээрх тогтоолын ач холбогдлыг бууруулж байна.

3.8. Ажлын хэсгийн уул уурхайн экспортын бүтээгдэхүүний 2012 оны 2 дугаар сард баримталсан нүүрсний жишиг үнийн мэдээллийг гаалийн боомтуудаар ялгаатай тогтоож байжээ. Жишээ нь:

Ккал	Гашуун сухайт (ам.доллар)	Шивээ хүрэн (ам.доллар)
4000 хүртэл	76,3	74,0
4000-5500	90.6	86.0
5500 дээш	105.0	95.0
Боловсруулсан	145.0	-

3.9. БНХАУ 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 1 тонн хатуу коксжих нүүрс Монгол Улсын Ганц мод боомтоор 850 юань, Сэхээ боомтоор 630 юаниар тус тус импортлон авч байгаа бол Австрали улсаас Жинтан боомтоор дээрх нүүрсийг 1680 юань, Тяньжин боомтоор 1700 юаниар тус тус авч байна. Үүнээс үзэхэд, Монгол Улс, Австрали улсаас 2 дахин хямдаар БНХАУ-ын зах зээлд коксжих нүүрсийг нийлүүлж байна.

3.10. Энэ нь манай улсын хувьд БНХАУ-ын зах зээлийн хамгийн хямд нүүрсний бүс нутаг болох Өвөр Монголын мужуудад нүүрс нийлүүлж байгаатай холбоотой байна.

3.11. Монгол Улсын нүүрсний экспорт эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагууд 1 тонн түүхий нүүрсийг БНХАУ-д 40-90 мянган төгрөгөөр экспортолж байгаа атлаа дотоодын зах зээлд нүүрсийг өндөр үнээр ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад худалдан борлуулж байна. Тухайлбал, Цайз захад Багануурын 1 тонн нүүрс 90-100 мянган төгрөг, Хангай захад Налайхын 1 тонн нүүрс 100-125 мянган төгрөг байна.

3.12. 2011 онд “жижиг” Тавантолгойн нүүрсний үнэ 1 тонн нь 38 ам.доллар (уурхайн ам дээрх үнэ), “Саусгоби сэндс” ХХК-ийнх 60 гаруй ам.доллар, “Энержи Ресурс” ХХК-ийнх 90 гаруй ам.доллар, харин тус компанийн боловсруулсан нүүрс 150 ам.долларын үнэтэй байна.

3.13. Австралийн нүүрс Монголын коксжих нүүрснээс 2-3 дахин илүү үнэлгээтэй байгаа нь хэрэглээнд тохируулан боловсруулагдсан, тээвэрлэлтийн асуудал зохицуулагдсантай холбоотой байна.

3.14. Иймд монгол нүүрсийг бүс нутагтаа хүчтэй өрсөлдүүлэхийн тулд зөвхөн компаниудын хүчин чармайлтаас гадна төрийн бодлогын төвшинд хэлэлцэх, тээвэр, ложистикийн тохиролцоогоор зах зээлээ өргөтгөх, нэвтрэх гарц гаргах нь манай улсын нүүрсний салбар хөгжихөд чухал нөлөөтэй гэж үзэж байна.

3.15. Салбарын мэргэжилтнүүд гуравдагч оронд бүтээгдэхүүнээ гаргах талаар олон судалгаа хийснээс үзвэл, БНХАУ-ын Тяньжин боомтод хүргэх, эсвэл ОХУ-ын Алс дорнодоор дамжуулаад Ванино боомтод хүргэж чадсан тохиолдолд Япон, Солонгос улс руу экспортлох боломж бүрдэх ажээ. Мөн ТрансСибирийн төмөр замаар Балтийн тэнгисийн боомтуудад хүргэснээр Европын зах зээлд гаргах нэг зам байгаа ч тээвэрлэлтийн зардал нэмэгдэх учир нүүрсээ боловсруулж эцсийн бүтээгдэхүүн болгох шаардлага тулгарч байна.

3.16. Одоогоор боловсруулсан коксжих нүүрсний үнэ Өвөр Монголын Бугат эсвэл Ухай орчимд 1 тонн нь 1000 юань байгаа бол ган үйлдвэрлэлийн мужууд болох Хэбэй, Шианси, Таншанд 1400-1500 юань/тонн байна. Харин Монголын нүүрс 600 орчим юань/тонн үнэтэйгээр Сэхээ боомтод худалдаалагдаж байна.

3.17. Ашигт малтмалын тухай хуулийн 27.1.3-т “уурхайн эдэлбэрээс олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах” гэж заасан. Мөн Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын өмнө демпингийн үнээр буюу зах зээлийн үнээс хэт доогуур үнээр борлуулахгүй байх үүрэг хүлээсэн. Тиймээс дээрх хуулийн заалт болон энэ үүргийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.

3.18. Мэргэжилтнүүдийн тооцоолсноор дэлхийн төмрийн хүдрийн нөөц 1998 онд 213.0 тэрбум тонн байсан бол өнөөдөр 140.6 тэрбум тонн болтлоо буурч, төмрийн хэрэгцээ ч өссөн дүнтэй гарсан байна. Дэлхийн төмрийн хүдрийн нөөцийн 91 хувиас илүү нь 10 оронд төвлөрч байна. Тухайлбал, төмрийн хүдрийн олборлолтын хэмжээгээр Австрали 433.0 сая тонноор нэгд, Бразил 398.0 сая тонноор хоёрдугаарт, БНХАУ 359.0 сая тонноор гуравдугаарт, Энэтхэг 231.5 сая тонноор дөрөвдүгээрт тооцогдож байна.

3.19. Ази тивд төмрийн хүдрийн 17 хүртэлх хувь ногддог бөгөөд үүнээс Монгол Улсын хувьд төмрийн хүдрийн батлагдсан нийт нөөц 400 гаруй сая тонн буюу дэлхийн нөөцийн 0.5 хувийг эзэлж байна.

3.20. Төмөртэй, Баргилт, Баянгол, Төмөртолгойн ордыг улсын төсвийн хөрөнгөөр нөөцийг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын тогтоогдсон нийт нөөцийн 80 гаруй хувь буюу 367.98 сая тонн бодит болон боломжит хүдрийн нөөц эдгээр ордуудад ногдож байна.

3.21. Улсын хэмжээгээр 2011 онд нийт 5.8 сая тонн төмрийн хүдрийг экспортолсон байна. Үүнээс “Болдтөмөр Ерөө гол” ХХК 3.0 сая тонныг экспортолсон нь одоогийн байдлаар 70 гаруй жил ашиглах нөөц болж байгаа бөгөөд хэрвээ жилд 10.0 сая тоннд хүргэж ашиглавал ердөө л 36 жилийн хугацаанд төмрийн хүдрийн нөөцгүй болж, ирээдүй, хойч үеийн төмрийн хэрэглээг хангаж чадахгүйд хүрэхээр байна.

3.22. Монголын төмөрлөг, машин механизм үйлдвэрлэлийн үндэсний холбоо “Өнгөрсөн онд манай улсын төмрийн хүдрийн экспорт 2005 оныхоос 20.1 дахин өсч, нэг тонныг нь дунджаар 68 ам.доллараар буюу дэлхийн зах зээлийн үнээс 2.4 дахин хямд борлуулж, хар төмөрлөгийн үйлдвэрийн төрийн бодлого алдагдсанаас арван сарын хугацаанд Монгол улс 671.9 сая ам.долларын ашгаа алдсан байна” гэжээ.

3.23. Манай улсын гангийн болон төмрийн бүтээгдэхүүний жилийн хэрэгцээ 300-гаад мянган тонн боловч үүнийхээ 80 гаруй хувийг өмнөд хөршөөсөө импортлон авч байна. Бүтээн байгуулалтын томоохон хөтөлбөрүүд хэрэгжиж эхлэх үед төмрийн хэрэгцээ нэг сая тоннд хүрч, барилгын арматурын хэрэгцээ одоогийнхоос 70 хувь өсөх урьдчилсан тооцоо хийгджээ.

3.24. Иймд улс орныхоо стратегийн чухал түүхий эд болох төмрийн хүдрийг дотооддоо гүнзгийрүүлэн боловсруулалт хийж, ажлын байр бий болгон нэмүү өртөг шингээх, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг багасгах нөхцлийг бүрдүүлтэл төмрийн хүдрийн экспортыг зогсоох нь үндэсний эрх ашигт нийцэхээр байна.

2.2 Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг боловсронгуй болгох шаардлагатай байна


3.25. ЭБЭХС-ын 2010 оны 41 болон 2011 оны 148 дугаар тушаалаар Тосон-Уул XIX гэрээт талбайн нийт газрын тосны “баталгаат” нөөц 179.08 сая тонн, үүнээс газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөц 20.17 сая тонн гэж тогтоожээ.

3.26. ЭБЭХС-ын 2012 оны 97 дүгээр тушаалаар Тамсаг-XXI талбайн газрын тосны “баталгаат” нөөцийг 127.5 сая тонн, үүнээс байгалийн горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 14.01 сая тонн, ус шахалтын горимоор ашиглах газрын тосны “ашиглалтын баталгаат” нөөцийг 21.0 сая тонноор бүртгэсэн байна.

3.27. ЭБЭХС-ын 2011 оны 137 дугаар тушаалаар БХГ-97 талбайн газрын тосны “баталгаат” нөөцийг 26.05 сая тонн буюу 186.3 сая баррель, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 2.07 сая тонн буюу 14.86 сая баррелиар тус тус тогтоож, ГТГ-ын даргын 2011 оны 128 дугаар тушаалаар газрын тосны ашиглалт (үйлдвэрлэлийн олборлолт) явуулж эхлэхийг “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-д зөвшөөрсөн байна.



3.28. “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК Тосон-Уул XIX, Тамсаг-XXI талбайгаас 2005 оноос 2012 оны 9 дүгээр сар хүртэл нийт 9037.9 мянган баррель газрын тос олборлож, экспортод гаргаснаас нийт 205089.0 сая төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлжээ.




3.29. “Доншен Газрын тос (Монгол)” ХХК газрын тосны олборлолтыг Зүүнбаян Цагаан-Элсний орд газраас 1996 онд туршилтын журмаар эхэлж, улмаар 2005 оноос 2012 оны 9 дүгээр сарын байдлаар тус талбайгаас нийт 2709.9 мянган баррель газрын тос олборлон экспортолж, газрын тосны орлогоос нийт 67018.1 нàү төгрөгийг Монгол Улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.30. Эхний графикаас харахад,

“Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК 2009 оноос хойш түүхий газрын тосыг жил тутам 230.9-380.8 мянган баррелиар нэмэгдүүлэн төлөвлөж, экспортолсон байна.

3.31. Хоёр дахь графикаас харахад, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК 2009 онд газрын тосыг хамгийн их буюу 614.5 мянган баррелийг экспортолж, түүнээс хойш жил тутам 34.8-40.5 мянган баррелиар бууруулан экспортолсон байна.

Одоогоор батлагдаад буй газрын тосны нийт “ашиглалтын баталгаат” нөөц 36.25 сая



тонн болж байгаа бөгөөд 2011 онд 2.5 сая баррель буюу 333.9 мянган тонныг экспортолж, 2012 онд 3.6 сая баррель буюу 480.8 мянган тонныг экспортлох төлөвлөгөөтэй ажилласан байна. Үүнээс үзвэл, 75 орчим жил экспортлох нөөцтэй байна. Газрын тосны экспортын хэмжээ жилээс жилд нэмэгдсээр байгаа бөгөөд ингэснээр экспортлох жилийн хэмжээ багасах юм.

3.32. “Петрочайна Дачин Тамсаг Монгол”

ХХК-өөй Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайгаас экспортолж буй түүхий тосонд ачилт, буулгалтын зөрүү үүсэж, үүний дагуу Газрын тосны газраас экспортын түүхий тосны ачилт, буулгалтын зөрүүг арилгах талаар “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-тай удаа дараа уулзалт зохион байгуулж, албан тоот хүргүүлж байсан боловч өнөөг хүртэл тодорхой үр дүнд хүрээгүй байна. Тухайлбал,

- Газрын тосны газрын даргын 2012 оны 37 дугаар тушаалаар “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX талбайд баригдсан Та-1 олборлолтын ил байгууламжаас экспортолж буй түүхий тосонд ачилт, буулгалтын зөрүү үүсэж буй шатлгааныг тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан байна.
- Тус ажлын хэсгээс гаргасан шийдвэрийг үндэслэн Газрын тосны газрын дарга 2012 оны 1-510 тоот мэдэгдэлдээ “Тамсагийн сав газраас олборлон борлуулж буй түүхий тосны Монгол Улсын Засгийн газарт ногдох тоо хэмжээг 2012 оны 3 дугаар сарын 1-ээс эхлэн Тосон-Уул XIX, Тамсаг-XXI талбайнууд дээрх хөндлөнгийн эрх бүхий байгууллагын хэмжсэн хэмжилтээр тооцох,
- Мөн 2011 оны 11 дүгээр сарын 26-аас 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийг хүртлэх экспортын тосны ачилт, буулгалтын зөрүүнээс үүдэлтэй 438936.61 ам.долларын хохирлыг 2012 оны 6 дугаар сарын 1-ний дотор барагдуулах” гэсэн албан бичгийг “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-д тус тус хүргүүлж байжээ.
- Түүнчлэн 2012 оны 3 дугаар сарын 1-нээс 8 дугаар сарын 1-ний өдрийн хооронд ачиж, буулгасан газрын тосноос 504.7 мянган ам.долларын зөрүү гарсан байна.

Монгол Улс газрын тосны салбарт Бүтээгдэхүүн хуваах гэрээг ашиглаж байна

3.33. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулах зарчим нь тухайн орны газрын тосны геологи, геофизикийн судалгаа болон нөөц ямар түвшинд судлагдсан байдлаас хамаардаг байна.

3.34. Норвеги Улсын Петрад төвийн газрын тосны гэрээ, эрх зүйн орчинд хийсэн судалгаагаар, дэлхийн 132 орон концессийн буюу лицензийн гэрээ (роялти, татварын), бүтээгдэхүүн хуваах гэрээ, үйлчилгээний гэрээ гэсэн үндсэн гурван зарчмыг баримталж áàéìà.

3.35. Олон улсын хэмжээнд нийтдээ концессийн гэрээгээр 55 (41.6 хувь), бүтээгдэхүүн хуваах зарчмаар 65 (49.2 хувь), үйлчилгээний гэрээгээр 12 (9.1 хувь)

орон тус тус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж байгааг тогтоожээ.

3.36. Газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээ байгуулсан байдлыг бүс нутаг, улс орнуудаар нь ялган дор харуулав.

Бүс нутгаар:	Концессийн гэрээ	Үйлчилгээний гэрээ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
Ази Номхон далайн орнууд	Австрали, Бруней, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Тайланд	Филлипин	Бангладеш, Камбож, БНХАУ, Энэтхэг, Индонези, Лаос, Малайз, Монгол, Мянмар, Пакистан, Тимор, Вьетнам, Непал, Шри Ланк
Төв Ази	Казакстан ОХУ	-	Азербайжан, Грузин, Казакстан, Киргизстан, Туркменстан, Узбекистан
Латин Америк	Аргентин, Болив, Колумб, Коста Рика, ФалкЛанд арал, Парагвай	Бразил, Гондурас, Чили, Панама, Эквадор, Перу, Венесуэл,	Белиз, Куба, Гватемал, Гуана, Ямайка, Никарагуа, Панама, Уругвай
Ойрхи Дорнод	Арабын НЭУ: (Абу Дхаби, Ажман, Дубай, Фужарах, Шаржах); Турк	Иран, Кувейт, Сауди Араб	Бахрейн, Ирак, Иордан, Ливи, Оман, Катар, Сири, Иемен
Хойд Америк	Канад АНУ	-	-
Африк	ӨАБНУ, Чад, Конго, Гана, Мадагаскар, Малави, Мали, Морокко, Намиб, Нигер, Синегал, Сэйчиллес, Сомали, Тунис	-	Алжир, Ангол, Венин, Камерун, Конго, Коти Д Ивойри, Египет, Гвиней, Итиоп, Габон, Гамби, Кени, Либири, Ливи, Мадагаскар, Мозамбик, Нигер, Судан, Танзан, Тонго, Тунис, Уганда, Замби
Европ	Болгар, Чех, Герман, Франц, Грек, Унгар, Ирланд, Итали, Нидерланд, Норвеги, Польш, Португал, Румын, Испани, Англи	-	Албан, Малти, Польш, Турк

3.37. Монгол Улсын газрын тосны салбарт хайгуул, судалгаа хангалтгүй хийгдсэн, улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийхэд зардал өндөртэй, эрсдэл ихтэй, мөн салбарын боловсон хүчин хангалтгүй бэлтгэгдсэн зэргээс шалтгаалан дээр дурдсан үндсэн зарчмуудаас Бүтээгдэхүүн хуваах гэрээг хэрэглэж байна.

3.38. Тус гэрээг газрын тосны нөөц нь тогтоогдоогүй, хайгуул судалгааны ажил огт хийгдээгүй, эсвэл хайгуул судалгааны ажил анхан шатандаа явагдаж байгаа, геологи тектоник хөдөлгөөн идэвхтэй явагдсан, газрын тостой хэдий ч ордууд нь сарнимал байдалтай орших олонх орнууд хэрэглэдэг байна.

3.39. Газрын тосны хайгуул, ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ний гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг-XXI, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн гэрээт БХГ-97 зэрэг талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти), ашигт тосыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

№	Бүтээгдэхүүн	Гэрээ	Гэрээ батлагдсан	Ашигт тос
---	--------------	-------	------------------	-----------

хуваах гэрээний нэр	байгуулсан компани	огноо	Роялти	(Хуанлийн сарын хуваах тосны өдрийн дундаж хэмжээ)
1. Тосон уул-ХИХ талбайд байгуулсан БХГ	АНУ-ын Медалион Ойл Монголиа компани	1993 оны 4-р сарын 26-ны өдрийн /1997.12.10/ Засгийн газрын 239 дугаар тогтоол	0	50000 баррелиас бага бол МУ-ын Засгийн газар 40 хувь, гэрээлэгч 60 хувийг, 50001-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг, 100001 их бол МУ-ын Засгийн газар 55 хувь, гэрээлэгч 45 хувийг тус тус эзэмшинэ.
2. Тамсаг-ХХI талбайд байгуулсан БХГ	Австралийн Комманд Петролеум, Цагаан шонхор, АНУ-ын СОКО консерциум	1996 оны 8-р сарын 7-ны өдрийн Засгийн газрын 183 дугаар тогтоол	7.5	50000 баррелиас бага бол МУ-ын Засгийн газарт 40 хувь, гэрээлэгч 60 хувийг, 50001-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг, 100001 их бол МУ-ын Засгийн газар 55 хувь, гэрээлэгч 45 хувийг тус тус эзэмшинэ.
3. БХГ-97 талбай байгуулсан БХГ	АНУ-ын Нескор Энержи компани	1997 оны 2-р сарын 19-ний өдрийн Засгийн газрын 47 дугаар тогтоол	7.5	25000 баррелиас бага бол МУ-ын Засгийн газар 38.75 хувь, гэрээлэгч 61.25 хувь, 25001-50000 бол МУ-ын Засгийн газар 45 хувь, гэрээлэгч 55 хувь, 50000-100000 бол МУ-ын Засгийн газар 50 хувь, гэрээлэгч 50 хувийг тус тус эзэмшинэ.

3.40. “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК өдөрт 8000-10000 баррель газрын тосыг олборлон экспортолж байгаа бөгөөд БХГ ёсоор 50001 баррелиас илүү олборлож байж Монгол Улсын Засгийн газарт ногдох ашигт тосны хэмжээ 50 хувьд хүрэх юм. Гэтэл одоогийн экспортын хэмжээнээс харахад газрын тосны олборлолт 50000 баррельд хүрнэ гэдэг ойлголт бараг үгүй учраас манай улсын Засгийн газарт ногдох хувь хэмжээ 40 хувиас хэтрэхгүй юм.

3.41. “Доншен Газрын тос (Монгол)” ХХК өдөрт ойролцоогоор 2692.8 баррель газрын тос олборлож, экспортолж байгаа бөгөөд БХГ-д тусгагдсанаар 25000 баррельд хүрч Монголын талд ногдох ашигт тосны хэмжээ 38.5 хувиас давах боломж мөн алга байна.

3.42. Мөн “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ний гэрээт Тамсаг-ХХI, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн гэрээт БХГ-97 зэрэг талбайд байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр болох роялтийг 7.5 хувиар байгуулсан бөгөөд харин Тосон-Уул ХИХ гэрээт талбайн БХГ-нд нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти) байхгүй байна.

3.43. “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Тосон-Уул ХИХ талбайгаас 2005 оноос 2012 оны 9 дүгээр сар хүртэлх хугацаанд олборлож, экспортолсон 6787.2 мянган баррель газрын тосноос нөхөн сэргээгдэшгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти)-ийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2-т заасны дагуу 5 хувиар тооцож үзэхэд, улсын төсвийн орлогыг 32.8 тэрбум, 7.5 хувиар тооцоход 49.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Газрын тосны салбарт ашиглаж буй Бүтээгдэхүүн хуваах гэрээг өөрчлөх шаардлагатай байна

3.44. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь Ашигт малтмалын тухай хуулийн 47.3.2-т “...тухайн уурхайн эдэлбэрээс олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 5.0 хувьтай тэнцүү” байхаар заагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газар газрын тосны хайгуул,

олборлолт, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх 13 гэрээлэгчтэй байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнд 7.5 хувь, Олон улсын жишигт 3.5-12.0 хувьтай байдаг байна.

3.45. Иймд, Газрын тосны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсаны дараа Тосон-Уул XIX талбайн бүтээгдэхүүн хуваах гэрээнд байгалийн нөхөн сэргээгдэхгүй нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7.5 хувиас доошгүй байхаар өөрчилж, мөн дээр дурдсан ашигт тосны хоногт олборлох баррель хэмжээг багасгаж (тухайлбал, 50000-г 5000 баррель болгон өөрчлөх г.м), Монголын Улсын Засгийн газарт ногдох хэмжээг нэмэгдүүлэн өөрчлөх нь зүйтэй.

3.46. Үүнээс гадна, газрын тосны хайгуулын нийт 30 талбай байгаагаас газрын тосны хайгуулын 18 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 15 гэрээлэгч компани газрын тостой холбогдсон үйл ажиллагааг явуулж байгаа бөгөөд тэдгээр бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг ч мөн газрын тосны тухай шинэчилсэн хуульд нийцүүлэн холбогдох өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай.

“Амбер” ХХК хөндлөнгийн, хараат бус хяналт, шинжилгээ хийж чадахгүй байна

3.47. Тосон уул-ХИХ, Тамсаг-ХХИ гэрээт талбай дахь “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК, БХГ-97 гэрээт талбай дахь “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-уудын газрын тосны экспортын үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж буй “Амбер” ХХК нь Стандартчилал, хэмжил зүйн газраас 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдөр MNS ISO/IEC17025:2007 стандартын шаардлага хангаж “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лаборатори”-ийн С №029 дугаарт итгэмжлэлийг Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 2-р хороо Нарын зам-11 тоотод байрлах лабораторит авсан бөгөөд итгэмжлэлийг 2012 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр дахин сунгажээ.

3.48. **Тамсаг дахь “Амбер” ХХК-ийн үйл ажиллагаа.** Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт харьяалагдах 5030382 регистрийн дугаартай “Амбер” ХХК нь “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-тай Тамсаг дахь Олборлолтын ил байгууламжаас экспортод ачигдаж буй газрын тосонд тоо, чанарын буюу тосон дахь усны хувь хэмжээг тодорхойлох гэрээг 2011 оны 8 дугаар сарын 15-ны өдөр англи, монгол хэл дээр хийжээ.




Тамсаг дахь “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн лабораторийн нэрлэгийн аппарат, дээж авах шугамын цэг, “Амбер” ХХК-ийн өмч болох термометр

3.49. Гэрээний 3.7-т “Гүйцэтгэгч нь өөрийн тоног төхөөрөмж болон ажилчдын даатгалыг өөрийн зардлаар хариуцна” гэж заасан боловч усны хувийн жинг

- Амбер компанийн төлөөлөгч ачилт хийхийн өмнө тос ачих 21 вагонд үлдэгдэл тос байгаа эсэхэд шалгаж, хэмжилт хийж тэмдэглэл хөтөлж байв



- Ачихад бэлэн болсон газрын тос агуулж байгаа 1002, 1005 дугаар танкнаас 2 хятад ажилчид дээж авч байв.



- Авсан дээжээ лабораторид аваачиж, 200 мл-ийг хэмжилт хийн авч, тусгай зориулалтын шилэн саванд хийн дээр нь 200 мл бинзин хийж, 30 минут нэрж, усны хувийн жинг тодорхойлж байна ($0.02 \times 100 / 200 = 0.01$).



- Газрын тосноос дээж авах, шинжилгээ хийх, усны хувийн жинг тооцоолох бүх ажиллагааг “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн ажилтнууд өөрийн байр, техник, багаж хэрэгсэл дээр хийж байсан бөгөөд “Амбер” ХХК-ийн ажилтан зөвхөн хөндлөнгөөс л ажиглаж байв.

3.56. Дээжлэн авсан шингэн тосыг 30 минутын турш халаан нэрлэг явуулж, шингэн тос, усны хувийн жинг тодорхойлж, үүнийг үндэслэн Газрын тосны газрын төлөөлөгч болон “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн төлөөлөгчидтэй газрын тосны цэвэр жинг тооцоолон төлбөр тооцоо хийх баримтыг үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулж байна.

3.57. Дээрх байдлаас харахад, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-ийн ажилтнууд газрын тосны лабораторийн шинжилгээ хийхдээ дээж авах, шинжилгээ хийх үйл ажиллагааг өөрийн байр, техник, багаж хэрэгсэл дээрээ хийж байгаагаас үзэхэд хөндлөнгийн хараат бус “Амбер” ХХК-ийг лабораторийн шинжилгээ хийн усны хувийн жинг тодорхойлж байна гэж үзэх үндэслэл үндсэндээ алга байна.

3.58. Нөгөө талаар газрын тосны дээж дээр 200 мл бензин (20 литрийн савнаас хийж буй бензин нь ямар төрлийнх болох, ус холилдсон эсэх нь тогтоох боломжгүй) хийж шингэлээд нэрлэг хийж усны хувийн жинг үнэн зөв бодитой хийж байгаа эсэх нь эргэлзээ төрүүлж байна.

3.59. Газрын тосны төлбөр тооцоог хийхдээ Зүүнбаянгаас ачигдсанаар бус БНХАУ-д буусан тоо хэмжээг үндэслэн тооцоог хийж байгаа бөгөөд Эрээн хотод вагоноос вагонд сэлгэн ачилт хийгээд байхад газрын тосны зөрүү гарахгүй байгааг анзаарахгүй байж болохгүй юм.

3.60. Энэ нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 13.2-т “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори, баталгаажуулалт, техникийн хяналт явуулах байгууллага нь заавал итгэмжлэгдэнэ” гэж заасныг зөрчиж байгаа бөгөөд хөндлөнгийн хараат бус хяналтын чиг үүрэг хэрэгжиж чадахгүй байна.

2.3 Лабораторийн шинжилгээгээр ашигт малтмалын дагалдах элементүүдийг бүрэн тодорхойлохгүй байна

3.61. Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоол, 2010 оны 39 дүгээр тогтоолд заасан уул уурхайн экспортын бүтээгдэхүүний баримтлах жишиг үнийг тогтоох зорилгоор зарим төрлийн уул уурхайн бүтээгдэхүүний үндсэн болон үнэт металлын агууламжийг тодорхойлсон шинжилгээг үндэслэн барааны ангиллын кодыг тодорхойлсон дүгнэлтийг ГаТЛ гаргаж, түүнийг үндэслэн гаалийн үнийг тогтоож байна.

3.62. ГаТЛ хайлуур жоншны хүдэр, баяжмал, цайр, зэсийн баяжмалын үндсэн агууламж, бүх хүдэр баяжмалын чийгшлийг тодорхойлж, харин бусад эрдэс болон нүүрсний шинжилгээг хамтран ажиллах гэрээний дагуу олон улсын итгэмжлэгдсэн Геологийн төв лаборатори, СХЗГ-аас итгэмжлэгдсэн Уул уурхайн хүрээлэнгийн нүүрсний хяналтын лабораторид хийлгэсэн шинжилгээний үр дүнг үндэслэн дүгнэлт гаргаж байна.

3.63. Мөн зарим уул уурхайн бүтээгдэхүүн экспортлогч аж ахуйн нэгжүүд болох “Монголын алт” ХХК, “SGS “ХХК, “Эрдэнэт” үйлдвэртэй хамтран ажиллах гэрээ байгуулан, өөрсдийнх нь итгэмжлэгдсэн лабораторийн үр дүнг үндэслэн уг дүгнэлтийг гаргаж байна.

3.64. Лабораторийн шинжилгээгээр Засгийн газрын дээрх тогтоолуудад заасан уул уурхайн бүтээгдэхүүний тухайн сард баримтлах жишиг үнийн мэдээлэлд заасан элементүүдийг тодорхойлж байна.

3.65. Харин бусад элементүүдийг нэмж тодорхойлсон тохиолдолд уг тогтоолд заагдаагүй учраас үнийг тогтоох боломжгүйгээс гадна аж ахуйн нэгж, байгууллагууд нь тэдний гадаад худалдааны гэрээнд заагаагүй болон өөрсдийн албан хүсэлт гаргаагүй тохиолдолд иж бүрэн шинжилгээ хийлгэх, дагалдах элементийг шинжлүүлж илүү төлбөр төлөхөөс татгалздаг байна.

3.66. ГеТЛ хүдэр баяжмалд гаалийн төв лабораторийн хүсэлтийн дагуу дээжинд агуулагдах алт, мөнгөний агууламжийг тодорхойлдог бөгөөд захиалагчийн хүсэлтийн дагуу бүх төрлийн хүдэр, баяжмалд дагалдах элементүүдийг тодорхойлох боломжтой.

3.67. Харин алтны агууламжийг <0.03 мг/кг гэж бичдэг нь шинжилгээний аргын 95 хувийн үнэмшил магадлалтай тодорхойлж буй хамгийн бага хязгаар бөгөөд шаардлагатай тохиолдолд өөр төрлийн шинжилгээний арга хэрэглэн илүү бага агууламжийг тодорхойлох үйл ажиллагаа хийгдэхгүй байна гэж үзэхээр байна.

3.68. Тухайлбал, 2011 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн экспортод гаргасан гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлэгт хавсаргасан ГеТЛ-ийн дүгнэлтэд төмрийн хүдрийн баяжмалд алтны агууламж <0.03 мг/кг, мөнгө <2.0 мг/кг, төмөр 46.41, чийгшил 3.61 хувь гэж тодорхойлжээ. Шинжилгээний дүгнэлт, гаалийн мэдүүлгээс үзэхэд дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Тус лаборатори алт, мөнгө зэрэг дагалдах элементүүдийн хэмжээг бүрэн тодорхойлж болох (ГеТЛ-ийн 2012 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1154 тоот албан бичиг) атал тодорхой зааж өгөөгүй, их багийн тэмдгээр хязгаарласан;
- Чийгийн хэмжээг 3.61 хувь гэсэн үзүүлэлтийг үндэслэн (ГЕГ-ын 2011 оны 12 дугаар сарын 13-ны 16/4488 албан тоот) төмрийн бохир жингээс 70200 кг-аас 2534.22 кг-ыг хасч 67665.78 кг-аас тооцож 67665.78 төгрөгийн хураамжийг гаалийн байгууллага авч байна. Гэтэл худалдан авагч байгууллага төмрийн хүдрийн баяжмалын үнийг нэхэмжлэлийг 70200 кг-аар тооцож төлж байна. Ингэснээр гаалийн байгууллага хураамжийг 1 вагоноос 2534.22 төгрөг дутуу авч байна. Зөвхөн 2012 онд тус компаний 2516478.9 тонныг экспортоор гаргасан гэж үзвэл, чийгийг дунджаар 3 хувь гэж үзэхэд 75494.4 тонн буюу 75.5 сая төгрөгийн хураамжийг дутуу авч байна гэж үзэхээр байна.

3.69. Дорнод аймаг дахь гаалийн газар экспортод гаргаж буй түүхий нефтийн бүтээгдэхүүнд иж бүрэн шинжилгээ хийх лабораторийг 2011 онд ашиглалтад оруулсан боловч түүхий нефтийг Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоол, 2010 оны 39 дүгээр тогтоолуудад орхигдуулсан учир лабораторийн шинжилгээнд хамруулж чадахгүй байна.

3.70. Цаашид экспортын ашигт малтмал, эрдэс бүтээгдэхүүний гадаад худалдааг боловсронгуй болгохын тулд түүхий нефть болон хүдэр баяжмалын дагалдах элемент бүрийн биржийн жишиг үнийг тогтоож баримтлах талаар Засгийн газрын 2010 оны 39 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлд ямар төрлийн ашигт малтмал, эрдэс түүхий эдийн зөвшөөрөл хамаарах болон дагалдах эрдэс түүхий эдийн талаар дэлгэрэнгүй тусгаж өгөх нь зүйтэй байна.

3.71. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тавьсан хүсэлтийн дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Шинжилгээний төв лаборатори, Монголын ашигт малтмал баяжуулагчдын холбоо хамтран БНХАУ-ын “Шинь Шинь” ХХК-ний эзэмшдэг Дорнод

аймгийн нутаг дахь “Улааны” хар тугалга, цайрын баяжуулах үйлдвэрт технологийн аудитыг хийжээ.

3.72. Аудитын үр дүнд боловсруулсан баяжмалууд дахь алт болон мөнгөний агуулга маш өндөр байсан байна. 2011 оны эхний 8 сарын байдлаар хартугалганы 4.457 тн баяжмалд 10.18 тн мөнгө, 139.51 тн зэс, 40.71 кг алт, 2.46 тн кобальт, 347.67 кг селен, 6.340 мян.тн цайрын баяжмалд 1.85 тн мөнгө, 71.64 тн зэс, 13.81 кг алт, 3.83 тн кобальт, 158.49 кг селен тус тус агуулагдаж байгааг тогтоожээ.

3.73. Дээрх дагалдах элементүүдийн ихэнх нь хар тугалганы баяжмалд агуулагдаж байсан бөгөөд цаашид өнгөт болон үнэт металлуудыг ялангуяа зэсийг салган боловсруулах технологийг нэвтрүүлэх эсвэл баяжмалын худалдааны үнэд нэмж тусган тооцох шаардлагатайг харуулж байна гэж үзжээ.

ДҮГНЭЛТ

Аудитын үр дүнтэй холбогдуулан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хуульд уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох харилцааг зохицуулсан заалт тодорхойгүй, Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоог хангаж ажиллах журамгүй, тэдгээрийн чиг үүрэгт бүрэн тусгагдаагүй байна.
- Уул уурхайн салбарыг хөгжүүлэх талаар зарим бодлогын баримт бичгийг боловсруулсан ч батлагдаагүйн зэрэгцээ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эрх зүйн орчныг шинэчлэх ажил удаашралтай байна.
- ЭБЭХЯ-ны ажлын хэсгийн тогтоосон уул уурхайн экспортын бүтээгдэхүүнд баримтлах жишиг үнийг мөрдөх явцад татварын болон аж ахуйн нэгж, байгууллагуудын хооронд зарим талаар тодорхой бус байдал үүсгэж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн маргаан гарч байна.
- Хилийн мэргэжлийн хяналтын алба уул уурхайн мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай, итгэмжлэгдсэн лабораторигүй, эрх зүйн орчин хангалтгүйгээс ашигт малтмалыг экспортлох үйл ажиллагаанд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна.
- Сангийн яам болон Гаалийн ерөнхий газраас баталсан журамгүйгээр тус газрын Эрсдэлийн удирдлага, үнэлгээ бүрдүүлэлтийн шалгалтын хэлтсийн даргын албан бичгийн дагуу 2009 оноос эхлэн экспортод гаргаж байгаа төмрийн хүдрийн баяжмалаас гаалийн хураамжийг авахдаа чийгийн хэмжээг хассан цэвэр жингээр тооцох аргачлал хэрэглэж байгаа нь эрх зүйн хувьд эргэлзээтэйгээс гадна төсөвт орох орлогыг тодорхой хэмжээгээр бууруулж байна.
- Гаалийн ерөнхий газрын даргын 2010 оны 402 дугаар тушаалаар экспортод гаргах уул уурхайн бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамжийг 1 тонн тутамд 1000-1500 төгрөгөөр тооцон татваргүйгээр экспортолж байгаа нь эдийн засгийн ач холбогдол багатай байна.
- Дорнод аймаг дахь Гаалийн газарт экспортын түүхий нефтийн бүтээгдэхүүнд хяналт тавих зорилгоор иж бүрэн лабораторийг 2011 онд ашиглалтад оруулсан боловч Засгийн газрын 2007 оны 88, 2010 оны 39 дүгээр тогтоолд холбогдох өөрчлөлт хийгдээгүйгээс шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх зүйн үндэс бүрдээгүй байна.
- Гаалийн ерөнхий газрын Төв лаборатори уул уурхайн экспортын бүтээгдэхүүнд шинжилгээг хийхдээ гаалийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр зөвхөн зэс, төмрийн хүдэр, баяжмал, цайр, гянтболд зэрэг ашигт малтмалын

агууламжийн хувь хэмжээг тодорхойлж байгаа боловч дагалдах элементүүдийг бүрэн тогтоож, дүгнэлт гаргахгүй байна.

- “Биржийн нэр зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоол нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуультай зөрчилдөж байгаагаас гаалийн үнэлгээний аргуудыг уул уурхайн экспортын бүтээгдэхүүнд дэс дараалан хэрэглэх хяналтын зарчим алдагдаж байна.
- Төмрийн хүдэр, баяжмалыг 2011 онд экспортолж 45.5 тэрбум төгрөг улсын төсөвт орсон бөгөөд үүнээс 1 тонн тутамд ногдох үр өгөөжийг тооцож үзэхэд 7852.80 төгрөг гарч байгаа нь маш бага байна.
- Газрын тосны Бүтээгдэхүүн хуваах 1993, 1997 оны гэрээнүүдэд өдөрт олборлох газрын тосны хэмжээг 50001 баррелиас давуулсан нөхцөлд Монгол Улсын Засгийн газарт ногдох хувь хэмжээг өсгөж 50 хувьд хүргэх нөхцөл тусгагдсан нь бодит байдал дээр хэрэгжих боломжгүй байгааг өөрчлөх, Бүтээгдэхүүн хуваах 1993 оны гэрээнд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг ашигласны төлбөр (роялти) төлөх тухай заалтыг нэмж оруулах шаардлагатай байна.
- “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК газрын тосыг Тамсагаас хэмжилт хийж ачуулж байгаа боловч төлбөрийг БНХАУ-д хүлээж авснаар тооцож байгаагаас зөвхөн 2012 оны 3 дугаар сарын 1-нээс 8 дугаар сарын 1-ний өдрийн хооронд ачиж, буулгасан газрын тосноос 504.7 мянган ам.долларын зөрүү гарч, хоёр улсын байгууллагын хооронд маргаантай байдал үүсч байна.
- “Амбер” ХХК экспортод ачигдаж буй газрын тосон дахь усны хувь хэмжээг тодорхойлохдоо үйлчлүүлэгч компанийхаа байр, лабораторийн техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ашиглаж байгаа нь хараат бус байх шаардлагыг хангахгүй, чанарын хяналтыг бодитой хийхэд эрсдэлтэй байдлыг бий болгож байна.
- Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний тээвэрлэлтээс хөрсний эвдрэл бий болж, тоосжилт үүсэн говийн экосистем алдагдах, цөлжилтийн нэмэгдүүлж, тухайн орчинд амьдарч байгаа иргэд, малчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл, мал амьтны бэлчээр нутгийг доройтож, ашигт малтмал олборлох, нүүрс тээвэрлэхтэй холбогдсон зам тээврийн осол сүүлийн жилүүдэд өсч байна.
- Ашигт малтмалын газраас 2010 оны байдлаар гаргасан судалгаагаар 61.0 мянга гаруй хувиараа ашигт малтмал олборлогчид ажиллаж байгаагаас 98.42 хувь нь алтны үндсэн ба шороон ордод олборлолт явуулж байгаа боловч олборлосон алтаа Монголбанкинд тушаадаг эсэх болон бусад ашигт малтмалыг хэрхэн худалдан борлуулдаг нь тодорхойгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Уул уурхайн сайд Д.Ганхуягт

1. Эрдэс баялгийн болон нүүрсний салбарын, үүний дотор уул уурхайн бүтээгдэхүүний гадаад, дотоод худалдааны бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, хууль эрх зүйн өөрчлөлт, шинэчлэлт хийх,
2. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах 1993,1997 оны гэрээнүүдэд Монгол Улсад ногдох хувь хэмжээг өсгөх нөхцлийг өөрчлөх, байгалийн баялаг ашигласны төлбөрийг (роялти) төлдөг болох чиглэлээр хууль эрх зүйн орчинд өөрчлөлт хийх болон газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтыг зохицуулахад бүтээгдэхүүн хуваах гэрээнээс гадна концессийн болон үйлчилгээний гэрээний зарчмыг хэрэглэх зэрэг асуудлыг судалж шийдвэрлэх,
3. Зах зээлийн жишиг үнийн талаарх мэдээллийг гаргаж буй ажлын хэсгийн үйл ажиллагааг сайжруулах, үнийн эх сурвалжийг олон улсын жишигт хүргэх, нийтэлж буй мэдээллийн чанарыг сайжруулах, үүрэг, хариуцлагыг чангатгах, Засгийн газрын 2007 оны 88 дугаар тогтоолд заасан www.coalword.net сайтад зарласан үнийг баримтлан жишиг үнэ тогтоож байгаа үндэслэлийг дахин судалж, холбогдох арга хэмжээ авах,
4. Төмрийн хүдэр, нүүрс зэрэг ашигт малтмалыг дотооддоо боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортын үр өгөөжийг нэмэгдүүлэх асуудлыг судалж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, хууль эрх зүйн актад тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах,
5. Монгол Улсын авто болон төмөр замын сүлжээг хөгжүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд ашигт малтмал, ялангуяа нүүрсний тээвэрлэлт, ложистик, дэд бүтцийн хөгжлийн асуудлыг иж бүрэн шийдвэрлүүлэх.
6. Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулж, уул уурхайн экспортын бүтээгдэхүүний дагалдах элементүүдийг лабораторийн шинжилгээгээр бүрэн тодорхойлуулж, дүгнэлт гаргуулах асуудлыг шийдвэрлэх.
7. Уул уурхайн бирж байгуулах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх

Газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Өлзийбүрэнд

1. Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээг өөрчлөхдөө байгалийн нөхөн сэргээгдэшгүй нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7.5 хувиас доошгүй байх, Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газарт ногдох ашигт тосны хувь хэмжээг тогтоож буй хоногийн олборлолтын хэмжээг багасгах замаар нэмэгдүүлэн өөрчлөх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх,

2. “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн Тамсагаас тос, усны хэмжээг тогтоон хэмжилт хийж ачигдсан газрын тосны төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс ачигдсан тоо хэмжээгээр тооцон авах асуудлыг шийдвэрлэх.

Ашигт малтмалын газрын дарга Г. Алтансүхэд

1. Нүүрс, жонш, гянтболд зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлох үйл ажиллагаанд тавих хяналт болон холбогдох төрийн бусад байгууллагуудтай ажлын уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх,
2. Уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод гаргах үйл ажиллагааг зохицуулах журмын төслийг боловсруулж, хэрэгжүүлэх
3. Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийг нөхөрлөлийн зохион байгуулалтад оруулах замаар ашигт малтмал олборлох, худалдан борлуулах үйл ажиллагааны статистик мэдээллийг гаргах,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазарт

1. Ашигт малтмал экспортлож буй боомтуудыг уул уурхайн бүтээгдэхүүнд шинжилгээ хийж дүгнэлт гаргах лабораториудаар хангах, хилийн мэргэжлийн хяналтын албыг уул уурхайн мэргэжлийн улсын байцаагчаар бэхжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх
2. Мэргэжлийн хяналтын албаны лабораторийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж итгэмжлэгдсэн лаборатори болгож, уул уурхайн бүтээгдэхүүний дагалдах элементийг тодорхойлох боломж нөхцлийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх

Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ганбатад

1. Төмрийн хүдрийн баяжмалаас чийгийн хэмжээг хасаж цэвэр жингээр бодож хураамжийг тооцож байгаа аргачлалыг эргэн харж, бохир жингээр тооцон гаалийн хураамж авч, бүрдүүлэлтийг хийх асуудлыг судалж шийдвэрлэх,
2. Түүхий нефтийн биржийн үнэ, үнэлгээний талаарх Засгийн газрын холбогдох тогтоолуудад өөрчлөлт оруулж, эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх
3. Стратегийн ач холбогдол бүхий алт, зэс, төмрийн хүдэр, баяжмал, нүүрс гэх мэт зарим ашигт малтмалыг экспортлоход гаалийн татвартай болгох асуудлыг судалж шийдвэрлүүлэх,
4. Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулж, уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг болон дагалдах элементүүдийг лабораторийн шинжилгээгээр бүрэн тодорхойлон дүгнэлт гаргаж байх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

Холбогдох байгууллагын санал

Уул уурхайн
яамны санал

Тайлбар 1



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81

2013.01.03 № 1/22
танай 2012.12.17-ны № 1154 -т

Санал хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн Экспортод гаргаж буй зарим ашигт малтмалын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна.

Аудитын тайлангийн төслийн 1.59-д "... 2011 онд 5.8 сая тонн, 605.5 тэрбум төгрөгийн өртөгтэй төмрийн хүдэр, баяжмал экспортлосноос улсын төсөвт нийт 45.5 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. ..." гэсэн байна. Өртөг гэдэг нь тухайн бүтээгдэхүүнийг олборлохоос эхлээд экспортлох хүртэл бүх зардал тооцогддог болно. Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний татвар гэдэгт Гаалийн татвараас гадна Хүн амын орлогын албан татвар, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр, Газар, ус ашигласны төлбөр, Тээврийн хэрэгслийн татвар, Орлогын албан татвар гэх мэт татварууд хамрагддаг гэж ойлгож байна. Энэ заалттай холбоотой 1.61 заалт дахь "Гэтэл бид газрын хэвлийд буй байгалийн үнэт баялгаа маш бага хэмжээний өртгөөр экспортолж байгаа нь улс орон, ард түмэнд үр өгөөж муутай байна." гэсэн дүгнэлтэнд өөрчлөлт оруулж өгнө үү.

Таны зөвлөмжийн дагуу тайлангийн төслийн 2.34-т заасан ачилт, буулгалтын зөрүүг арилгахаар газрын тосны хэмжилтийн цэгийг Монгол улсын нутаг дэвсгэрт авч байхаар 2012 оны 12 дугаар сарын 1-ний өдөр Газрын тосны газар болон Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн хооронд хийсэн хэлэлцээрт тусган шийдвэрлэсэн.

Аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа тусгаж ажиллана.

Жич: Шинэчлэлийн Засгийн газар байгуулагдсан үеэс "Эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ын төсөл, "Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ын төсөлд яамны санал бэлдэх, боловсруулах, Газрын тосын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн санал боловсруулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдэд нэмэлт өөрчлөлт оруулах, Газрын тосын бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газрын тосны бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай хуулийн төслийг шинээр боловсруулах болон салбарын хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг Ажлын хэсгүүд байгуулан ажиллаж байна.

САЙД



Д.ГАНХУЯГ

69 0016

Үндэсний аудитын газрын тайлбар

Тайлбар 1

Уул уурхайн яамнаас ирүүлсэн саналыг хүлээн авч тайлангийн 1.59, 1.61-т холбогдох засварыг оруулсан болно.

Ашигт малтмалын газраас ирүүлсэн саналын тайлбар

Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.14-т Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт “Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавина”, мөн ЭБЭХС-ын 2009 оны 72 дугаар “Ашигт малтмалын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч, шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан хөтөлбөрийн 3.2.3.14-т “Нүүрсний уурхайнуудын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, нүүрсний экспортод хяналт тавих....” гэж заасан байдаг.

Иймд дээрх хууль болон хяналтын чиг үүргийг боловсронгуй болгож, хэрэгжилтийг бүрэн хангуулах чиглэлээр зөвлөмж өгсөн болно.

Тус газраас ирүүлсэн 2 дах саналыг хүлээн авч найруулгын өөрчлөлтийг тайланд тусгав.

Газрын тосны газраас ирүүлсэн саналын тайлбар

Тус газраас ирүүлсэн 1 дэх саналыг хүлээн авч, тайлангийн зөвлөмж хэсэгт тусгав. Харин 2 дах саналыг 1 дэх зөвлөмжийн агуулгад багтсан гэж үзэж, засвар хийсэнгүй.

Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн саналын тайлбар

Тус газраас ирүүлсэн 1 дэх саналд төмрийн хүдрийн экспортод гаалийн бүрдүүлэлтийг хийхдээ Гаалийн төв лабораторийн дүгнэлтийг үндэслэн нийт жингээс чийгийн хэмжээг хувиар тооцон хасаж цэвэр жингээр тооцон гаалийн хураамжийг авч байгаа боловч аж ахуйн нэгж байгууллагууд нийт жингээр бодож төлбөрийг худалдан авагч талаас нэхэмжлэн авч байна. Мөн дээрх аргачлалаар чийгийн хэмжээг тооцон хасч байх тушаал шийдвэр ч байхгүй байгаа тул засвар хийсэнгүй.

Мөн 2 дахь саналд Дорнод дахь гаалийн лаборатори нь итгэмжлэл авч дүгнэлт гаргах эрхтэй болсон боловч тайлангийн дүгнэлтэд Засгийн газрын холбогдох тогтоолуудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар цаашид эрх зүйн үндэс бүрдүүлэх тухай асуудлыг хөндсөн гэж үзэж байгаа тул засвар хийх шаардлагагүй гэж үзлээ.

Харин 3 дахь саналыг хүлээн авч, тайланд найруулгын өөрчлөлтийг хийв.



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2012.10.18 № 02/78 ҮАГ-ГАГ/2012/ГА-10

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ САЙД
Д.ГАНХУЯГ ТАНАА

Газрын тосны зөрүүгийн тухай

Тус газраас “Экспортод гаргаж буй зарим ашигт малтмалын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” сэдвээр Газрын тосны газар, болон Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн газрын тос олборлох, экспортод гаргах үйл ажиллагаанд аудит хийв.

Аудитаар “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК нь Тамсагийн сав газраас олборлосон тосны бүтээгдэхүүний усыг нь ялган цэвэршүүлж, хөндлөнгийн эрх бүхий “Амбер” ХХК-аар тоо, чанарын хэмжилт хийлгэж түүний үр дүнгээр төлбөрийг тооцон ачуулсан атал БНХАУ-ын Рашаантад буусан дүнгээр төлбөрийн тооцоог хийж байгаа зөрчил илрэв.

ТА-1 олборлолтын ил байгууламжаас 2012 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 1-ний хооронд ачиж, буулгасан газрын тосны зөрүү 21,164.59 баррель бөгөөд үүнээс Монгол Улсын Засгийн газарт ногдох тосны орлого 504,715.52 ам.долларын хохирол хүлээх болж байна.

Иймд “Төрийн аудитын тухай” хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...” гэсэн заалтыг үндэслэн Тосон уул-ХИХ гэрээт талбай дахь ТА-1 олборлолтын ил байгууламжаар усыг нь ялган цэвэршүүлж, хөндлөнгийн эрх бүхий “Амбер” компанийн хэмжилтийн дүнгээр төлбөрийг тооцож байх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсад өнөөгийн байдлаар 504,715.52 ам.долларын бодит хохирол учирч байгааг харгалзан Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг хуульчлан шийдвэрлүүлэхийг Газрын тосны газрын орлогч дарга бөгөөд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Өлзийбүрэн, “Петрочайна Дачин Тамсаг Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мэргэнсод нарт ШААРДЛАГА хүргүүлж байна.

Бичсэн
Үндэсний аудитын газрын
Ахлах аудитор
Шинжээч
Т.Цэдэнбалжир
С.Пүрэвсүрэн

АЛБАН ШААРДЛАГА

Танилцаж, зөвшөөрсөн:
Газрын тосны газрын орлогч дарга
бөгөөд даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
Г.Өлзийбүрэн
“Петрочайна Дачин Тамсаг Монгол”
ХХК-ийн гүйцэтгэх захирал
С.Мэргэнсод

070300



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2013 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. “Экспортод гаргаж буй зарим ашигт малтмалын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Өлзийбүрэн, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ганбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазар нарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг, Газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Өлзийбүрэн, Ашигт малтмалын газрын дарга Г.Алтансүх, Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Ганбат, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Гүнбазар нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Б.Баттуяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070022